



ӨМНӨГОВЬ АЙМАГ

ОРОН НУТГИЙН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймгийн
2019 оны 11 ДҮГЭЭР сарын мэдээ

Нэг. Удирлага, зохион байгуулалтын хүрээнд

- ***Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл***
- ***Байгууллагын хүний нөөцийн чиглэлээр***

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийт 276 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөл дээр хянуулан төрийн албаны зөвлөлийн ээлжит 41 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, батлах зөвшөөрөл авлаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/281 дүгээр тушаалаар албан тушаалын тодорхойлолт тус бүрийг баталгаажуулж, байгууллагын нийт албан хаагчдад шинээр баталгаажсан албан тушаалын тодорхойлолтыг танилцууллаа.

Мөн төрийн албаны ерөнхий шалгалтыг 11 дүгээр сарын 16-21-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Шалгалтад нийт 237 иргэн бүртгүүлснээс 3 дугаар шатанд 27 иргэн тэнцэж төрийн албаны нөөцөд бүртгэгдлээ. 11 сарын 21-ний өдөр аймгийн хэмжээнд “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх” ёслолын ажиллагааг амжилттай зохион байгуулж 38 албан хаагч тангараг өргөлөө.
- ***Дотоод ажил, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чиглэлээр***

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 11 дүгээр сарын байдлаар иргэдээс 477 өргөдөл, хүсэлт ирүүлснээс 448 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгсөн бөгөөд 29 өргөдөл шийдвэрлэх хугацаандаа явж байна. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн түвшинг сайжруулах чиглэлээр 11 дүгээр сарын 19-ний өдөр сум, байгууллагын дотоод ажил, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнүүд болох 40 гаруй албан хаагчид “Санал, өргөдөл гомдлыг шийдвэрлэлт” сэдвээр сургалт зохион байгууллаа. Түүнчлэн байгууллагын, нэгжийн, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, үнэлэх арга зүйн талаар сургалтыг зохион байгууллаа.

11 дүгээр сарын байдлаар байгууллагын хэмжээнд хугацаа хэтэрсэн өргөдөл, гомлол байхгүй, байгууллагын шуурхай хурлыг 1 удаа зохион байгуулсан мэдээтэй байна.
- ***Гадаад харилцаа, нутгийн захиргааны байгууллагын чиглэлээр***

Даланзадгад сумын 4, 8 дугаар башт “Хөдөлгөөнт баг” арга хэмжээг зохион байгуулж, 2 багийн 240 гаруй иргэнд 15 байгууллагын 30 гаруй үйлчилгээг хүргэж ажилласан. Дипломат болон албан паспорт эзэмшдэг албан тушаалтнуудыг судалгааг аймгийн Засаг даргын Тамгын газар, 15 сум, 22 агентлагуудаас авч нэгтгэн Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүлэв. 15 сум, 2 агентлагын дарга нарын албан паспортыг Консулын газарт мэдүүлэв. Төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа төлбөр, хураамжтай үйлчилгээг цахимжуулах үйл ажиллагааг зохион байгуулах агентлагуудын мэргэжилтнүүдийн судалгааг 22 агентлаг 8 төсөвт байгууллагуудаас авч, Сангийн яаманд хүргүүлэв.

ӨМӨЗО-ны Баяннуур аймаг, Альшаа аймгуудад туршлага судлах 2 хэсэг бүрэлдэхүүний зохион байгуулалтыг хийж, арга хэмжээнд хамруулав. БНСУ-ын Гусон сумтай хамтран ажиллах саналыг боловсруулан, туршлага судлах хүсэлтийг хүргүүлж, мэдээлэл солилцож ажиллав. 11 дүгээр сард 14 бичгийн хариуг хүргүүлж, гадаад арга хэмжээ болон Зөгийн үүр хөтөлбөрт хамрагдах албан тушаалтны захирамжийг болвсруулан шийдвэрийг хүргүүлсэн байна.
- ***Сум, орон нутгийн чиглэлээр***

Аймгийн хэмжээнд 15 сум, 59 багийн иргэдийг хамруулан төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай үзүүлэх чиглэлээр “Хөдөлгөөнт баг” арга хэмжээг амжилттай зохион байгуулж, нэгдсэн дүн мэдээг энэ сард гаргалаа. Төрийн нийт 30 гаруй байгууллагын 80 гаруй төрлийн

үйлчилгээг багийн төв дээр зохион байгуулж давхардсан тоогоор аймгийн хэмжээнд 42830 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлж ажилласан байна.

Аймгийн хэмжээний 59 багийн дарга нарын дунд сайн туршлага судлуулах, мэдээлэл өгөх зорилгоор “Иргэн төвтэй төрийн албыг төлөвлүүлэх нь” сэдэвт сургалт туршлага солилцох арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Туршлага судлах арга хэмжээнд үлгэр жишээ багаар Баяндалай сумын Наран багийг тодруулж, нийт багийн дарга нарыг багийн төв дээр хийгдсэн бүтээн байгуулалтуудтай танилцууллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

- Эрүүл мэндийн чиглэлээр

Шүдний кабинет нь хүн амд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Шимбилэг өрхийн эрүүл мэндийн төвд шүдний шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм материалаар, хүний нөөцөөр хангаж Шүдний кабинетийг нээн ажиллуулж эхэлсэн. Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийн дэмжих нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад сумын хүн амд явуулын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ явуулын үзлэг оношилгоог Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч мэргэжилтгүүд хамтран зохион байгуулж нийт үзлэгт эрэгтэй 545, эмэгтэй 1224 нийт 1769 хүнд, 2547 удаагийн үзлэг, шинжилгээ хийсэн. Зорилтод нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдээс 10.2%-ийг эмэгтэйчүүд эмчийн үзлэг, БЗДХ-ын шинжилгээ, оношилгоонд хамруулсан байна.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр

Цогтцэций сумын Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын тасал, Таван толгой ХК-ийн ажилтан, албан хаагчдад “Цагаан туузтаны өдөрлөг”, “Уул уурхай дахь жендэрийн эрх тэгш байдал хэлэлцүүлэг” арга хэмжээг зохион байгуулж 180 гаруй хүн оролцлоо. “Говийн хөгжлийн түүхээ” аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг амжилттай зохион байгуулж, 15 сумын 150 хүүхэд оролцлоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг угтаж Даланзадгад сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг арга хэмжээг зохион байгууллаа. Өдөрлөгт Даланзадгад сумын 8 багийн 150 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл хамрагдлаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн улсын үзлэгийг Цогтцэций, Ханбогд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудад 2019 оны 11 сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Улсын үзлэгт 15 аж ахуйн нэгж хамрагдлаа.

- Боловсролын чиглэлээр

Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн урлагийн заалны барилгыг хүлээн авч байнгын ашиглалтад орууллаа. БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг 2019 оны 11 сарын 02-03-ны өдрүүдэд манай аймагт ажиллалаа. Хөгжимт жүжгийн театр, Музей, Соёл спортын цогцолбор, Багшийн хөгжлийн төвийн барилгын үйл явцтай танилцлаа. Даланзадгад сумын 8, 9 дүгээр цэцэрлэгт дэвсгэр, БТСГ-т 2 автомашины зардлыг шийдвэрлэхээр болсон. Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүд-2019, Халхын голд зөвлөлт Монголын цэргийн байгуулсан ялалтын 80 жилийн ойн хүрээнд орос хэлний төвийн бүсийн олимпиад, дуу, шүлгийн уралдааныг 11-р сарын 01-02-ний өдрүүдэд Даланзадгад хотод зохион байгууллаа. Орос хэлний бүсийн олимпиадад Өмнөговь, Төв, Дундговь аймгийн 18 сургуулийн 19 багш, 14 сургуулийн 12-р ангийн 24 сурагч оролцлоо. Мөн 7-12-р ангийн сурагчдын дунд орос дуу, шүлгийн уралдааныг зохион байгуулж, тус уралдаанд 50 гаруй сурагч авьяас чадвараараа өрсөлдөж, аваргууддаа тодрууллаа. “Оюуны хурд” хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад сумын 3 дугаар сургууль дээр 2019 оны 11 сарын 16-ны өдөр АБТА Д.Үзмээгийн нэрэмжит Геометрийн олимпиадыг зохион байгууллаа. Багш, 9-12 дугаар ангийн нийт 200 гаруй хүн оролцож, оюун ухаанаа уралдуулан шилдгүүдээ тодруулан, шагнаж урамшууллаа. “Англи хэлтэй-Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд 11 сарын 16-ны өдөр Гадаад хэлний баяр, англи хэлний стандарт олимпиадыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 780 гаруй багш, сурагч оролцсон юм. Багш, сурагчид англи хэлний мэдлэг чадвар сорихын зэрэгцээ англи дуу шүлэг, жүжигчилсэн тоглолтоор оролцлоо. 2019 оны 11 сарын 20-ны аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Ханбогд сумын 2 дугаар сургуулийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийлээ. Тус хяналт шалгалтаар Төрийн албаны стандарт, хууль

тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, хандив тусламж, эд хөрөнгийн бүртгэл тооцоо зэргийг шалгаж, багш нараас санал асуулга авч ажиллалаа.

Тав. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр

- Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

“Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх” багц-1 ӨМАОНӨГ/2018120064 дугаар гэрээт ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2019.10.24-ний А/1114 захирамжаар ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Б.Отгондаваагаар ахлуулсан мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл 17 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан 11 сарын 04-ний өдөр ажилласан. Орон нутгийн аялал жуулчлалын хөгжилд томоохон түлхэц болохуйц шийдлүүдийг гаргах зорилгоор олон талын оролцоотойгоор “Говийн аялал-Цогц үйлчилгээ” аялал жуулчлалын салбарын зөвлөгөөнийг 2019 оны 11 сарын 11-ний өдөр зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд аймгийн Засаг даргын орлогч С.Мөнхбаяр, ЗДТГ-н ХОХБТХ-н дарга Ж.Сүх-Эрдэнэ БОАЖЯ-ын аялал жуулчлал бодлого зохицуулалтын ахлах мэргэжилтэн Н.Молор болон байгаль орчин аялал жуулчлалын салбарын албан хаагчид, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж хувь хүн нийт 100 орчим иргэн оролцов. Тус зөвлөгөөний хүрээнд 11 сарын 08-10-ны өдрүүдэд аялал жуулчлалын салбарт ажиллаж буй жолооч, хөтөч, тайлбарлагч, тогооч нарт зориулсан мэргэшүүлэх сургалтад 150 иргэн оролцож гэрчилгээ гардуулав. Баянзагийн соёлын өвийг хамгаалах чиглэлээр 2019 онд 424,1 сая төгрөгөөр тохижилтын ажлыг "Хан богд ариажих" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж хүлээн авсан байна. Менежментийн төлөвлөгөөний дагуу 2019 онд нэвтрэх цэг, хамгаалалтын хашаа, машины зогсоол, тасалбар таслах, мөн төсвийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалт, байгаль орчин, палеонтологийн ховор нандин олдворуудыг хамгаалахаар нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаар хариуцуулах сонгон шалгаруулалтыг 1 сарын хугацаанд олон нийтэд нээлттэй зарлаж "Баян заг- Улалзах цонж төв" НҮТББ сонгон шалгаруулалтад тэнцэж гэрээ байгуулан үйл ажиллагаагаа 06 сараас эхлэн хариуцан ажиллаж байна.

Зургаа. Төсөв, санхүүгийн чиглэлээр

Нийт 43 төсөвт байгууллагуудын 2019 оны 10 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан. Төсвийн орлогын 10-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулан хүлээн авлаа. Орон нутгийн байгууллагуудын 10 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ. Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 11-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо. Аймгийн төрийн сангийн харьяа 43 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа. Аймгийн 15 сумаас ирүүлсэн Фрийбаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд хяналт тавин ажиллалаа. Нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг сум, байгууллагуудаас аван нээж ажиллалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сайдын тушаалаар баталсан журам заавар, жишиг баримт бичгүүдийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэв.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр

Аймгийн ЗДТГ-г зохион байгуулагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй”, Дорноговь аймагт болсон “Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагад нэвтрүүлэх нь” сургалтад хамрагдсан. Шинээр гарсан бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэн аймгийн удирдлага, нэгжийн дарга нарт танилцуулах, хяналтад авах, хариуцсан албан тушаалтанд хүргэх ажил үргэлжилж байна. Нийт 15 сумын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Агентлаг, сумын ХШҮ-ний ажилтнуудын 2 өдрийн нэгдсэн сургалтыг зохион байгуулав. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил үргэлжилж байна.

СУМДЫН МЭДЭЭ

БАЯН-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн:

ЗДТГазар:

А Захирамж 12 гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Хамтын ажиллагаа түншлэлийн хүрээнд сумын ИТХ-н төлөөлөгчид Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн хороодын иргэний танхимуудын үйл ажиллагаатай танилцаж, нутгийн удирдлагын холбоон дээр 1 өдрийн сургалтанд хамрагдлаа. “Байгаль эх хариуцлагатай уул уурхай”, Альша аймгийн туршлага судлах арга хэмжээ, эм бэлдмэл ашиглах малын эрүүл мэнд сэдэвт сургалтуудад сумын ЗДТГ-ын албан хаагчид хамрагдлаа. "Говийн хөгжлийн түүчээ" хүүхдийн чуулган, “Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх арга зүйн сургалт, “Архи согтууруулах ундаа, мансууруулах бодис, донтолтоос сэргийлэх сургалтуудад тус тус хамрагдсан байна.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Сумынхаа 31 төрийн албан хаагчаа Өвөр Монголын Өөртөө засах орны Ордос болон Бугат хотуудтай танилцах аялалыг УИХ-н гишүүн Л.Энхболдын дэмжлэгтэйгээр хамтран зохион байгууллаа. Сумын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах хүрээнд уурын зуухны шинэ барилга барих ажил удаашралтай байсныг орон нутгаас хамтарч дэмжин халаалтаа амжилттай эхлүүлээ. Хөдөө аж ахуйг дэмжих жилийн хүрээнд сумын хэмжээнд ОСХөрөнгөөр 10 гүн өрмийн худаг шинээр гаргаж, 5 гүн өрмийн худагт нарны цахилгаан үүсгүүр суурилууллаа.

БУЛГАН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

-Засаг дарга нь 11 дүгээр сарын байдлаар Гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай 2, Ажлын хэсэг байгуулах тухай 2, Хөрөнгө зарцуулах тухай 1, Б.Даваасүрэнд ээлжийн амралтын хуваарь батлах тухай 1 нийт 6 захирамж гаргасан. Тамгын газрын дарга нь 11 дүгээр сарын байдлаар Үнэлгээний хороо байгуулах тухай 1 тушаал гаргасан. 11-р сард ар гэрийн шалтгаанаар 3 багш, ажилтан ажлаас чөлөөлөгдөж, 2 ажилтан /дотуур байрыг жижүүр, үйлчлэгч/ шинээр авлаа

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт .

Соёлын төвийн эрхлэгч, номын санч нар “Соёлын өв, соёлын үйлдвэрлэл үйлчилгээ” сургалтанд 3 хоног хамрагдсан.Уртын дууны сургалтанд Шаравдорж, Золзаяа хоёр хүн хамрууллаа.Эрүүл мэндийн төвийн 3-н мэргэжилтэн аймагт сургалтанд хамрагдсан.Багш, ажилчдын цуглааныг нэг удаа зохион байгуулж захирал, нягтлан бодогч нар цалин хөлс, санхүүжилтын талаар дэлгэрэнгүй тайлбарлан ойлголт өглөө.Баруун тахи хөгжүүлэх “Соробан” сампингийн сургалт хичээллэж эхлээд байна. Бүх багш нарт Улаанбаатар хотоос бүх сум сургуулиар сургалт хийж байгаа хүнийг авчирч нэг өдрийн компьютерийн сургалт, шинээр гар утсыг хэрхэн таньж авах, принтерийг хэрхэн ашиглах талаарх сургалтууд явагдаж, багш нөүтбоок, компьютертээ программ суулгуулж заавар зөвлөгөө авлаа.Цэцэрлэгийн эрхлэгч Өвөрхангай аймагт болсон туршлага судлах бүсийн семинарт явсан.Аймгийн хэмжээнд бүх сумын хамтарсан багуудын хариуцлагатай хамтарсан баг сургалт зөвлөгөөн маш амжилттай зохион байгуулагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Төсөвт байгууллагуудын 10-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээг нэгтгэн Төрийн сангийн программд шивж мэдээлэв.10-р сарын Орон нутгийн орлогыг хаалтын дансруу хааж, гүйцэтгэлийг татварын байцаагчтай тулган аймагт мэдээлэв.Аймгаас ирсэн 2019 оны 11-р сарын санхүүгийн дэмжлэгийг орлогын дансанд хааж, орон нутгийн байгууллагын санхүүжилтийг олгов. 2019 оны 10-р сарын шилэн дансны мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байршуулж, байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажиллав. Төсөвт байгууллагуудын 11-р сарын гүйлгээг хийж байна.ЗДТГ, Сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансны эрхийг нээлгэж, гүйлгээг хийж байна. Иргэдийн урьдчилсан үзлэгт 210 иргэн хамрагдсан.Витамин, дархлаажуулалт 16-н иргэн, түргэн тусламжийн дуудлага 2 ирсэн байна.

Тухайн сард зохион байгуулсан ажил

Ахмад багш Х.Агвааны гэрийг буулгаж цэвэрлэж өвлийн туурга, дээвэр давхарлаж тавьж гэрийг нь дулаалав. 1-3-р ангийн “Монгол ёс хүмүүжил”, 4-р ангийн “Эрүүл мэнд”, 6-9-р ангийн түрээсийн буюу төлбөртэй сурах бичгүүдийг хүлээн авч бүртгэж дансалж номерлов. Номын сангаас хэрэгцээ шаардлага хангахгүй болсон ном, сурах бичгийн жагсаалт гаргалаа. Өмчийн шалгалтанд бэлтгэж бүх багш, ажилчдаар “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-г байгуулж зурагжуулж, бусад материалуудыг бүрдүүлж бэлэн болгов. Ажилчдын заах аргын нэгдлийн хамт олон “Англи хэлтэй - Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд аймагт явагддаг англи хэлний олимпиадын бэлтгэл ажил жүжигчилсэн тоглолтын материалыг бэлтгэж, олимпиадаа амжилттай оролцож 3-р байр болон тусгай байранд шалгарлаа. Бүлгийн багш нар 7 хоногоор ээлжлэн хүүхдүүдийн дунд сургалт зохион байгуулж байгаа мөн дараа долоо хоногоос эхлэн эцэг эхчүүдэд зохион байгуулагдах төлөвлөгөөтэй байгаа.

Шинэлэг ажил

Соёлын төвийн дотоод засвар үйлчилгээ хийгдэж 2 давхарын шат шинэчлэгдсэн. Хөгжлийн бодлогын хэлтэсээс олгогдож байгаа хөгжим техник, тоног төхөөрөмжийг хүлээн авч тохижилт хийгдсэн. Цэцэрлэгийн коридорын тохижилт хийгдсэн.

2019 оны 12-р сард Камбожи улсад болох Соробан тэмцээний Дэлхийн аваргад өрсөлдөх 5а ангийн Г.Анар, 6а ангийн Г.Шүр нар бэлтгэлдээ гарлаа. Монгол хэл, уран зохиолын фистулийг монгол ёс заншилын агуулгаар иж бүрэн тохижууллаа. Физик, мэдээлэл зүй, хими биологи, түүх нийгмийн фистулийг шинээр тохижуулж байна.

ДАЛАНЗАДГАД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргын А захирамж 30, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 10, Б тушаал 4 тус тус гарсан байна.

2019 оны 11 сарын байдлаар 15 санал, хүсэлт, өргөдөл ирсэн. 6 өргөдөл гомдлыг шийдвэрлэж хаасан, 9 өргөдөл хугацаандаа явж байна. 70530002 утсанд 2 гомдол мэдээлэл ирснийг холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн хариу мэдэгдэж ажилласан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

Өмнөговь аймгийн Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны суурь судалгаа-2018 үр дүнг танилцуулах хуралд 8 Багийн Засаг Дарга нар хамрагдлаа. “Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” сургалт, туршлага солилцох арга хэмжээнд багийн Засаг дарга нар хамрагдлаа. Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Туршлагаа солилцож хамтдаа хөгжье” бүсийн сургалт, уралдаан тэмцээнд сумын Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын албаны 20 албан хаагчийг хамруулан оролцлоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах чиг хандлагыг өөрчлөх, нийгмийн харилцаанд татан оролцуулах сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх тэдний бие даан амьдрахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаа “Түгээмэл хөгжил” төвийн төлөөллийг сумын Засаг дарга хүлээн авч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургах, боловсролын эрх зүйн орчин болон арга зүйн дэвшилтэт хувилбаруудыг хэрэгжүүлэх талаар санал бодлоо солилцлоо. Сумын Засаг даргын санаачлагаар харьяа төсөвт байгууллагын 40 багшийг БНХАУ-д туршлага судлуулах арга хэмжээнд хамрууллаа. Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Малын эмч нар”-ын анхдугаар их хуралд мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, Цогцол ХХК-ны малын эмч Ш. Мандах нар оролцлоо. Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад сумын Засаг даргын Тамгын газрын болон төсөвт байгууллагын албан хаагчид хамрагдлаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хангагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулсан. 18-р байрны дулааны шугам сүлжээний доголдлын талаар иргэд хангагч байгууллагуудтай хамтарсан уулзалтыг 1 удаа зохион байгууллаа.

Байгууллагын шуурхай хурлыг 3 удаа хуралдлаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтаж Даланзадгад сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн уулзалт арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 140 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцож Нийгмийн даатгал Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмж,

Хөдөлмөр эрхлэлт, Төсөл хөтөлбөрт хамрагдах талаар, эрүүл мэндийн үйлчилгээ, дархлааг дэмжих талаар сургалт, “Аз жаргалтай амьдралын нууц” лекц зохион байгуулагдаж мэдлэг мэдээллийг нэмэгдүүллээ. Мөн нийгмийн харилцаанд идэвх санаачилгатай оролцож тэдгээр иргэдийн эрхийг хангах, төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж байгаа “Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо” болон зарим хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шагнаж урамшуулах, тэдгээр иргэдийн санал бодлыг сонсох зэрэг олон арга хэмжээ болж өндөрлөлөө.

“Хадлан тэжээл-2019” аяны 2019-2020 оны мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Даланзадгад сумын түнш байгууллагуудын дунд “Хадлан тэжээл-2019” аяныг зарласан бөгөөд тус аянд идэвхтэй оролцсон албан байгууллагуудад (1-р байрт “Оюуны мэлмий” 4-р бүрэн дунд сургууль, 2-р байрт “Цагдаагийн газар”, 3-р байрт “Санхүү хяналт, аудитын газар”) өргөмжлөл, дурсгалын зүйл хадгалуулав. Нийт 118 боодол өвс, 2 шуудай хивэг, 12 толгой шүдэнз, 20 толгой лаа, 6429 ширхэг зоодой, 647 шил даршилсан хөмүүл, 11-хошуувч, 637-нэмнээ, 40 шуудай модны навч бэлтгээд байна.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас 42,943,927 санхүүжилттэй 103542 толгой мал угаалга, ариутгалд 400 хашаа хороо бууц ариутгалд хамруулах ажил 102,4 хувь хэрэгжсэн байна.

Даланзадгад сумын хатуу хучилттай авто замын хэд хэдэн цэгт замын арчлалт хийж, эвдрэлийг засаж нөхөж байна. Даш зам ХХК уг ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд Даланзадгад сумын 6 дугаар баг, 2 дугаар баг, 3 дугаар баг, 5 дугаар сургуулийн зүүн талын зам, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн баруун тал, Улсын бүртгэлийн хэлтсийн зүүн хойно эвдрэл хэмхрэлтэй замуудыг нөхөж засварлаж дууслаа.

Дөрөв. Багт зохион байгуулагдсан ажлууд

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд чиглэсэн “Бизнесээ эхэл” сургалтанд 8 Багийн 16 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг хамрууллаа. Эрдэнэс таван толгой ХХК-аас зохион байгуулж буй “Хуримтлалтай–Хувьцаатай иргэн” аяны арга хэмжээнд 8 багийн 32 иргэн оролцлоо. Сумын Засаг даргын 2019 оны а/64 дүгээр захирамжийн дагуу бүх нийтийн их их цэвэрлэгээ зохион байгуулж 8 багийн хэмжээнд нийт 16 тн хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Хамтарсан багийг чадавхжуулах” сургалтад 8 багийн нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдийн хамт хамрагдлаа. Аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр зохион байгуулагдсан эрүүл мэндийн үзлэгт 8 багийн 60 иргэнийг хамрууллаа. “Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг зохион байгуулж “Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдвийн дор иргэдтэй уулзаж гомдол санал хүлээж авах уулзалтад 8 багийн 80 гаруй иргэн оролцлоо. Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 8 багийн зорилтот бүлгийн 90 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг хийж тайланг сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ. Явуулын номын сангийн үйлчилгээ, үйлчлүүлсэн иргэдийн тайланг Боловсрол, соёл хариуцсан бодлогын мэргэжилтэнд хүргүүлсэн. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Хариуцлагатай хамтарсан баг” сургалтад 8 багийн Нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдийн хамт хамрагдлаа. Замын цагдаагийн газар, сумын Засаг даргын Тамгын газраас хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл”, “бусдыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэх”, “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай” сургалтуудад 8 багийн Нийгмийн ажилтан хамрагдлаа.

МАНДАЛ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

Сумын ИТХ-н болон Тэргүүлэгчдийн тогтоол 2, сумын Засаг даргын захирамж 4, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 3 тус тус гарсан байна.

Хоёр. Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 3, албан байгууллагын дарга эрхлэгчдийн хурал цуглааныг 3 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар ярилцаж шийдвэрлэв.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинээр боловсруулан аймгийн ОБГ-т хянуулахаар хүргүүлэв. Дотоодын сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтыг 2 удаа зохион байгуулж, 39 албан хаагч хамрагдав. Сумын ЗДТГ-н төрийн албан хаагчдын харилцаа хандлага, үйлчилгээний чанарын талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 68,2 хувь нь Сайн, 29,2 хувь нь Дунд, 2,6 хувь нь Муу үнэлгээ өгсөн байв. Үнэлгээний мөрөөр ажил үйлчилгээ, харилцаа хандлага сайжруулах үүрэг чиглэлийг зохих мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгч, өдөр тутам үнэлгээ авч ажилласнаар иргэдийн сэтгэл ханамж дээшилж байна. Төрийн албан хаагчдын өдөр тутмын үйлчилгээнд иргэдээс сэтгэл ханамжийн үнэлгээ авах зорилгоор

“Найрсаг үйлчилгээ-ногоон карт” ажлыг хэрэгжүүлж байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ХХААГ-т хүргүүлэв. Эмэгтэйчүүдийн байгууллагын 60 жилийн ойн арга хэмжээг амжилттай зохион байгуулж үе үеийн дарга нарт хүндэтгэл үзүүлэн, эмэгтэйчүүдийн гар урлалын болон цагаан идээний үзэсгэлэн худалдаа, урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт 90 гаруй эмэгтэй оролцов. Хамтарсан багийн чадавхжуулах сургалтад 3 албан хаагч хамрагдав. Төрийн албаны шалгалтад 8 иргэн орж, 1 иргэн тэнцэв. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн ажлын зурагтай тайланг нэгтгэн ТЗУХ-т хүргүүлэв. Нэгдэлчдийн 60 жилийн ойн арга хэмжээнд 4 ахмадыг оролцуулав. Байгууллагуудын үйл ажиллагаа, ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд ХШҮ хийж, тайлан зөвлөмж хүргүүлэв. Говийн оюу ХДС-н 7 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийгдсэн Нийтийн эзэмшлийн талбайг усалтын системээр хангах Баян төгөл төслийг ажлын хэсэг хүлээн авав.

Дөрөв: Багт хийгдсэн ажлууд:

Баянхошуу багийн 60 жилийн ойн арга хэмжээ өргөн дэлгэр болж 3 насны тэмээний уралдаан, буухиа тэмцээн, сайхан буур, сайхан ингэ, сайхан хос шалгаруулах тэмцээнүүд зохион байгуулагдав.

МАНЛАЙ СУМ

НЭГ. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого, шийдвэр

Сумын Засаг дарга А захирамж 27, сумын Засаг даргын Б захирамж 4-ийг тус тус гаргасан байна.

ХОЁР. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

2019 оны 10.31-11.01-ний өдрүүдэд Өмнөговь аймагт Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дотоод ажил, эрх зүй хариуцсан мэргэжилтэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧ сургалтаар 16 цагийн хичээлийг судалж ГЭРЧИЛГЭЭ гардан авсан. Өвөрмонголын өөртөө засах орны Алша аймагт ХАА болон мал эмнэлгийн чиглэлээр туршлага судлах аялал арга хэмжээнд Мал эмнэлгийн тасгийн байцаагч А.Дуламсүрэн, С.Ганбаяр нар оролцсон. Төрийн албаны ерөнхий шалгалтад 8 иргэн шалгалт өгч 1 иргэн тэнцсэн. ХАМТАРСАН БАГИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ нь сургалтанд Хэсгийн цагдаа, нийгмийн ажилтан, сургуулийн төлөөлөл, эрүүл мэндийн төвийн эмч зэрэг нийт 4 хамтарсан багийн гишүүд төлөөлөлүүд суусан.Цэцэрлэгийн Бүлгийн багш Б.Мөнхнасан өмнөговь аймагт “Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах мэдлэг олгох сургалт”-д хамрагдсан. Цэцэрлэгийн Эд хариуцагч Р.Энхтөр 2019 оны 11 сарын 15-18 –д Улаанбаатр хотод сургалтанд хамрагдсан. Байгууллагуудын нийт 7 нягтлан няравууд УБ хотод Си ти эс -н санхүүгийн програмын нярав нягтлангийн 2 хоногийн сургалтанд хамрагдаад ирсэн. Багийн эмч Ш.Мөнхтуяа “Статистикч эмч нарыг чадавхжуулах” сургалтанд 2 хоног хамрагдсан.

ГУРАВ. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Шинэ Нутгийн удирдлагын ордныг албан ёсоор хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗДТГ-ын дарга ХШҮДАХ-т байгууллагын албан хаагчдын хувийн хэрэг бүрдүүлэлт, төсөвт байгууллагуудын болон өөрийн байгууллагын захирамжуудыг нь хянуулж шалгуулсан. Ард иргэдийн хүсэлт болон орон нутгийн удирдлагуудын урилгаар Жавзандамба хутагтын төвд Энэтхэгээс уригдаж ирсэн багш гэвш лхарамба Түвдэнчойсан тэргүүтэй Гандантэгчилэн хийдийн лам нар ирж Ямандаг бурханы Жинсрэг цутгаж, цаг бусын үхэл, элдэв гай зовлон, өвчин тахал тэргүүтэй өлзий бус бүхнийг арилгаж амирлуулдаг засал ном хийлээ. Аймгийн ИТХ-ын дарга Х.Сугир, Засаг даргын орлогч Мөнхбаяр нарын ирж төрийн албан хаагчид, ард иргэдтэй уулзалт ярилцлага хийсэн. 3 тн нүүрсний талаар мэдээллийг ТАВАН ТОЛГОЙ ХК-аас төлөөлөлүүд ирж мэдээлэл өгч иргэдэд 3тн нүүрсний талон тараасан. Үнэт цаасны компаниас төлөөлөл ирж нийт иргэдэд мэдээллийг хүргэсэн.

Тав. Багт хийгдсэн ажлууд:

Гэрийн эргэлтийн үзлэгийг нэмэгдүүлэн багийн эмч,их эмч нар 0-5 насны 316 хүүхэд, 96 ахмад настны эргэлтийг тогтмол хийж байна.

СЭВРЭЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргын 12 захирамж боловсруулагдан гарсан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,

Өмнөговь аймагт болсон “Товийн аялал-цогц үйлчилгээ” сэдэвт аялал жуулчлалын зөвлөгөөнд Хонгорын голд үйл ажиллагаа явуулдаг иргэд, Засаг даргын орлогч, Байгаль хамгаалагч нар оролцсон. “Нэгдэлжих хөдөлгөөний 60 жил”-ийн хуралд малчдын хамтаар оролцсон. Сумын төвд аймгийн Засаг даргын орлогч С.Мөнхбаяраар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж иргэдтэй уулзалт зохион байгуулсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

2019 оны 11 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд “Сэврэйн цом-2019” бөхийн барилдааныг Үндэсний бөх, Чөлөөт бөх, Жудо бөх гэсэн 3 төрлөөр зохион байгуулж Тэмцээнд 14 багийн 310 тамирчин сурагчид ирж өрсөлдөж Нийлбэр дүнгээр - Өмнөговь аймгийн Төрөлжсөн 7-р сургууль ТЭРГҮҮН байр, Өмнөговь аймгийн Сэврэй сумын “Цагаан суварганы хүчтэн” дэвжээ Дэд ТЭРГҮҮН байр, Өмнөговь аймгийн Ханбогд сумын "Ханбогд" бөхийн дэвжээ ГУТГААР байрыг тус тус эзэллээ

Эрүүл мэндийн төв шатахууны нөөц 2400,000 төгрөг байна. Эмнэлгийн яаралтай тусламжийн эм тарианы жагсаалтыг /алс ,ойр /стандартаар гарган орлого зарлагын хөтөлгөөг хийж байна. Тендерийн эмийн нөөц 2158,000 төгрөг, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орж ирсэн 58,6 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

2019-2020 онд сумын хэмжээн 365 малчин өрхийн 191473 толгой мал өвөлжинө. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Малчид өөрсдийн хүчээр бэлтгэсэн өвс, тэжээл хадлан 70 тонн, Сумын аюулгүйн нөөцөд 100 тонн өвсний нөөцтэй байна. Малчин өрхийн хашаа бууцны хангамж 90%, Өрхийн өвөлжилтийн бэлтгэл 87%-тай сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл дунджаар 82 хувьтай байна.

Мал угаалга, хашаа хороо ариутгалд Нийт-163304 толгой бог мал, 278 өвөлжөө хороо бууц ариутгаж шинээр Бүйлсэн багийн Хашаат 1 мал угаалгын суурин банн барьж Бүйлсэн багийн урд хоолойн Намын шилийн мал угаалгын суурин банныг сэргээн завсарласан. Мөн Хөдөө аж ахуй-үйлдвэржилтийн жилийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 9 дүгээр сард Сайншанд багийн Хулгар, Хоолт багийн Цагаан сүүжид шинээр 2 мал угаалгын банн барьсан.

Отроор өвөлжих 7 өрхийн 13 иргэн үүнээс 0-5 насны хүүхэд 2 байна. Оршин суугаа сумын ЭМТ-д дархлаажуулалт хяналтад бүрэн хамрагдаж байна. 9 сарын 30-ны байдлаар өөр аймаг сумдаас тус сумын нутагт отроор өвөлжих 3 өрхийн 8 иргэн, 1300 толгой мал байна.

Эрүүл мэндийн төвийн эмч ажилчид 1тн 500 кг өвс хадлан бэлтгэн малчин өрхийн өвөлжөөнд буулгасан байна. Мөн 46 хошуувч хийж 8 малчин өрхөд тараасан байна. Мөн малчин Амгаланбаатар, Наранцэцэг нарын гэрт очиж хашаа хороог янзлах, хотны хог чулууг түүж зайлуулсан байна. 2 өрхийн 1000 гаруй малын будаж тэмдэглэн халдвараас сэргийлэх тарилга хийх ажилд тусалсан байна.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил

Багш нарын дунд ээлжит хичээлийг чанаржуулахын тулд “Нээлттэй хичээлийг зохион байгууллаа . Нийт 5 багш хамрагдсан. Эцэг эхчүүдэд байгууллагын удирдлагын зүгээс “ Хүүхдийн эзэмших чадвар” сургалтыг зохион явуулсан ба нийт 73 эцэг эх хамрагдсан. Мөн эцэг эхчүүдэд өдрийн дэглэмийг танилцуулан үйл ажиллагаа болгоноо эцэг эхчүүдэд танилцуулсан ажил зохион байгуулсан нийт 102 хүн хамрагдаж танилцсан байна.

Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил:

Аав ээж би 3*3 сагсан бөмбөг, буухиа тэмцээнийг зохион байгуулан оролцож Ө.Аюушын гэр бүл тэргүүлээ. Эхний 3 байруудад Өргөмжлөл медаль гардууллаа. Бид ном уншдаг аймаг аяны хүрээнд Оюунлаг Сэврэйчүүд бүх нийтээрээ ном унших аяныг зарлан зохион байгуулж байна. -ЭМТ-ийн 2 тасгийг номын булантай болгох номын хандивын аяныг өрнүүлж байна.

Бусад ажил: Мянгатын хишиг хөтөлбөрт хамрагдаж 50 малтай боллоо.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 54сая төгрөгний өртөг бүхий аппаратур, тавилга тоног төхөөрөмжийг хүлээн авлаа. ХААҮ-ийг дэмжих жилийн хүрээнд Сайншанд багийн малчин Баяржаргалын очиж хороо бууц саравчийг янзалахад хамт олноороо дэмжлэг үзүүлээ.

ХАНБОГД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Засаг даргын захирамж- А-17, Б-1 , Засаг даргын Тамгын газрын даргын тушаал- 1,ИТХ-ын тогтоол -5 тус тус гаргасан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Ханбогд сумын иргэдээс ОТ ХХК-д ажиллах хүчний ихэнх хувийг эзэмшдэг SSM ХХК-ний удирдлага ажилчид оролцсон уулзалтанд хүсэлтийн дагуу оролцож сум орон нутгийн байр суурь ажилчдын нийгмийн асуудал болон тулгамдсан асуудалд хариулт өгч ажиллаа. Сумын “ХҮҮХЭД БИДНИЙ ИРЭЭДҮЙ” хүүхдийн чуулганыг зохион байгуулж энэхүү чуулганы хүрээнд “Төрд хүргэх миний үг” сэдэвт илтгэлийн уралдаан, ”Миний мөрөөдөл” гар зургийн уралдаан, ”Миний оролцоо бидний ирээдүй” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг нас насны ангилалаар зарлаж үр дүнг танилцуулан авьяас сурлагаараа тэргүүлсэн хүүхдүүдийг шагнаж урамшуулж, Аймгийн хүүхдийн чуулганд оролцох төлөөлөгч хүүхдүүдийг өөрсдийн саналаар сонгож, тулгамдсан асуудал болон эрх зүй нийгмийн чиглэлээр 4 бүлэгт хувааж санал санаачилга шийдэл зэргийг тусгасан шийдлийн гарцыг хэлэлцүүлгээр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгч Ханбогд сумын Хүүхдийн итгэмжит элч Б.Эрдэнэ-Очир, Сумын засаг дарга, Хүүхэд хамгаалалын хамтарсан багийн тэргүүн Ш.Эрдэнэжаргал, Сургуулийн захирал, Нийгмийн ажилтнууд, ЗХТ-ийн хамт олон болон Засаг даргын дэргэдэх залуучуудыг зөвлөл хамтран зохион байгуулж ажиллаа. Сумын өвсний агуулхын барилгын шавыг тавьж нээлтийг хийж хяналт тавин ажиллаж байна. Суманд хийгдэж буй үерийн далангийн ажилд хяналт тавьж хийгдэж буй ажилтай танилцаж нөхцөл байдлыг дүгнэж ажиллав. Галбын гурван хийдийн нэг болох Цагаан толгой хийдийн орчим Задгай театр барьж байгуулагсантай холбогдуулж Яруу найргийн наадмыг зохион байгуулж түрүүлсэн найрагчдыг шагнаж урамшууллаа. Энэхүү наадмыг нутгийн зөвлөлийн дарга д.Бат-Эрдэнэ ивээн тэтгэж явуулсан байна. Соёлыг дэмжих жилийн ажлын хүрээнд Ханбогд суманд Аялах дэвтэрийн хүрээнд Онцгой байдлын гал унтраах 66-р ангиас зохион байгуулсан дэвжээ тэмцээнийг явуулж ялагчаар шалгарсан 29-р цэцэрлэг “Яг түүн шиг” тэмцээнийг зохион байгуулж ажиллаа. Мөн уг тэмцээнд түрүүлж зохион байгуулах эрхийг авсан 2-р

4. Бусад ажлууд:

ХАНХОНГОР СУМ

Нэг.Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

Сумын засаг даргын 7 захирамж, Засаг даргын тамгын газрын даргын тушаал 6 гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт: Сумын ИТХ-аас иргэдийн нийтийн лекцийг 2 удаа зохион байгуулсан. Хог хаягдлын талаар иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж цаашид анхаарах асуудлыг тодорхойлж ажиллалаа. ХХҮХмэргэжилтэн Өрх гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл амьдрах зан үйл”, “Бага насны хүүхдийн чийрэгжүүлэлт”, “ Хувь хүний хөгжил “, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, “Санхүүгийн боловсрол гэж юу вэ?, “Хуримтлал хэрхэн бий болгох вэ?” зэрэг сэдвээр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Нийт 34 өрхийн төлөөллийг хамруулсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ:

-Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Сумын ИТХ-ын дэргэдэх ГХУССЗөвлөл соёл хүмүүжлийн 14 хоногийн аяныг зохион байгууллаа. Хог хаягдлын талаар хэлэлцүүлэг, шаардлагатай газруудад замын тэмдэгжүүлэлт хийх, нийтийн хог цэвэрлэгээ, сурагчдын дунд тулгамдсан асуудлаар сургалт хийх, үдшийн цэнгүүн, Хослон дууля уралдааныг тус тус төлөвлөн амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд Өгөөмөр багийн нутгаар дамжин өнгөрдөг автозам дээр анхааруулах тэмдэг 6, босоо цагдаа 2-ыг суурилуулсан. Бусад үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж тайлангаа аяны хавтсанд хавсаргаж ажиллалаа. Мөн ИТХ-ын тэргүүлэгчдийн 11-р дүгээр хурлыг зарлаж дараах асуудлуудыг шийдвэрлэлээ.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан

Шинэлэг ажил: Сумын ИТХ-аас хог хаягдлын талаар сумын иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж саналаа солилцлоо.Хэлэлцүүлэгт нийт 45 иргэн хамрагдсан. Хогны мөнгө төлөх үүрэг, төлбөр төлөхтэй холбоотой төлбөрийн даалгавар үүсгэх тухай татварын байцаагч мэдээлэл өгч ажиллалаа. Аймгийн

ГХУСАЗСЗөвлөл, Замын цагдаагийн тасгаас аваар осол гарч хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор тэмээний фосфортой хүзүүвчийг малчдад хүлээлгэн өгсөн байна.

Бусад ажил: Нийтийн их цэвэрлэгээг зохион байгууллаа. Нийт 2,5 тн хог хаягдлыг хаясан байна. Сумын 2019-2020 төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл 89,2 хувьтай байна. Улсын төсвийн хөрөнгөөр соёлын төвийн их засварын ажлыг улсын комисс хүлээн авч ашиглалтанд оруулсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 10-р цэцэрлэгийн цэвэр бохирын шугам тавих ажил болон дулааны шугамын шинэчлэл хийх ажлын гүйцэтгэлийг сумын ажлын хэсэг хүлээн авч ашиглалтанд оруулсан. Бусад байгууллагуудын хувьд өөрсдийн нөөц бололцоог ашиглан өвөлжилтийн бэлтгэлийг гүйцэтгэж байна. Ахмадын өргөөний дулааны шугамын холболт хийх ажлын гүйцэтгэл, замын тэмдэгжүүлэлт ажлыг хүлээн авсан. Мандах багийн конторын барилгын ажлын гүйцэтгэл 70 %-тай байна. Шавартайн услалтын системийн ажлын гүйцэтгэл 95 %-тай байна. Сумын музейн тохижилтын ажил хийгдэж байна. Гүйцэтгэл 90%-тай байна. "Энержи ресурс" ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан эрчим хүчний нүүрсийг гэрээ байгуулан татан авалтыг эхлүүлсэн байна. Эрчим хүчний нүүрсний нөөц одоогийн байдлаар 200 тн байна. Айл өрхийн хувьд "Таван толгой"-ХК-аас үнэгүй олгож байгаа 3 тн нүүрсний татан авалтыг зохион байгуулсан.

Багт хийгдсэн ажлууд:

Багийн төвд 2400 боодол өвсийг хувааж тараах ажлыг зохион байгуулсан. Багуудын Иргэдийн нийтийн хурлыг зохион байгууллаа. Иргэдээс ирүүлсэн өвөлжөө, хаваржаа эзэмших өргөдлийг шийдвэрлэх, сум орон нутгийн үйл ажиллагааны талаарх танилцуулга, эрүүл мэндийн үйлчилгээ, урлагийн арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Сумын төвийн байгууллагууд багуудын хооронд үүсгэсэн түншийн холбоог жил бүр бэхжүүлэн хамтран ажиллаж байна. Мэргэжлийн сургалттай сургуулийн хамт олон түншлэгч багийн малчин өрх М.Мөнхтоогогийнд бууцны хөр ховхлох зөөх, хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулсан байна. 10-р цэцэрлэгийн хувьд малчин Г.Батзаяагийнд хороо бууц засварлах ажлыг гүйцэтгэсэн байна. Сумын холбогдох байгууллагууд түнш багтаа хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулж нийт 6.5 тн хадлан бэлтгэж хүлээлгэн өгсөн байна. ЗДТГ Өгөөмөр багийн малчин Пүрэвийнд, Эрүүл мэндийн төв малчин Ө.Баттулгын, "Элка" ОНӨААТҮГ малчин Жигмэддоржийнд хөрзөн ховхлох, хороо бууц засварлах ажлыг зохион байгуулсан байна.

ЦОГТЦЭЦИЙ СУМ

Байгууллагын шуурхай хуралдааныг 4 удаа зохион байгууллаа. 10-р сарын 22 нд Хүүхдийн нэгдсэн Чуулга уулзалт зохион байгуулж 300 орчим сурагчдыг хамрууллаа. Сангийн яамны үүргийн дагуу санхүүгийн хяналт шалгалт ирээд ажиллаж байна. Аймгийн ГБХЗХГазраас сумын Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан багийн үйл ажиллагаа зэрэгт шалгалт хийлээ. Сумын ИТХурал мөн сумын Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан багийн үйл ажиллагааны тайланг жилийн эцсийн байдлаар хэлэлцэн дүгнэлт өглөө. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл хүссэн нийт 27 иргэн, ААНБ болон 59.6 км авто замын бүтээн байгуулалтанд Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээ байгуулсан Эсто ХХК, Нью Ланд Роуд ХХК 2 компань, Сумын төвийн 2.2 км хатуу хучилттай авто замд ашигласан Хүслэнт бүтээмж ХХК 1 компань бүртгэлтэй байна. 2019 оны 01 сараас-11 сарын 13-ны өдөр хүртэл нийт 33000000 сая төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. 3 га газарт хийгдсэн Техникийн нөхөн сэргээлтийг БОХУБ Э.Отгонжаргал, Цагаан овоо багийн Засаг дарга Ц.Баярсайхан, Байгаль хамгаалагч Т.Бадамцэцэг нар хүлээн авлаа. Хог хаягдлын энгийн хог шатаах зуухыг 48,420,000 төгрөгийн өртөгтэй Нийтийн хөгжил ХХК гүйцэтгэж Засаг даргын Тамгын газрын 2019 оны 11 сарын 07-ны өдрийн А/96 тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүлээж авч байнгын ашиглалтанд орууллаа. Таван Толгой Зүүн баян чиглэлийн 414.6 км төмөр замын дагуу Тус сумын нутаг дэвсгэрт байрлах трассын дагуу Байгаль орчны чиглэлээр хяналт шалгалт хийж шаардлагатай заавар зөвлөмжийг хүргүүлж тус ААН-үүдийн судалгааг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Хяналтаар тус сумын нутаг дэвсгэр дээр 11 компанийн 405 хүн, 279 техник хэрэгсэл ажилж байна. Туслах зам тавих ажилд 11 карьер ухагдаж 3 цооног шинээр өрөмдөж гаргасан. Цогтцэций сумын Засаг даргын 2019 оны 11 сарын 06-ны өдрийн А/242 дугаар захирамжийн дагуу Нийтийн хог цэвэрлэгээг 2019.11.09-2019.11.10-ны хооронд зохион байгууллаа. 25-30 тонн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт аваачлаа. Оюут улаан ХХК-ны Хармагтай хайгуулын талбайд хийгдсэн 39 цооног буюу нийт 53800 тууш метр өрөмдлөг хийсэн талбайн техникийн нөхөн сэргээлтийг 2018 оны 02 сарын 05-ны өдрийн А/23 дугаар дугаар ажлын хэсгийн дагуу хүлээж авлаа. Оюут улаан ХХК-ны Хармагтай хайгуулын талбайд хийгдсэн 39 цооног буюу нийт 53800 тууш метр өрөмдлөг хийсэн талбайн техникийн нөхөн сэргээлтийг 2018 оны 02 сарын 05-ны өдрийн А/23 дугаар дугаар ажлын хэсгийн дагуу хүлээж авлаа. Улсын бүртгэлийн байгууллагын нэгдсэн тогтолцоонд шилжээний 10 жилийн ойг тохиолдуулан 2019 оны 10 сарын 26-ны өдөр зохион байгуулсан НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ арга хэмжээний хүрээнд Цогтцэций сумын 10 гаруй иргэдэд Улсын бүртгэлийн нэн шаардлагатай үйлчилгээг үзүүлээ.